БАТЛАВ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН ДАРГА

.....С.ЖАРГАЛСАЙХАН

2025 оны 03 сарын 24 өдөр

АЖЛЫН ДААЛГАВАР

“ОРХОН АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН НӨӨЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН 2023-2024 ОНЫ ТАЙЛАНГ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГААР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ”

БОЛОВСРУУЛСАН:

БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН
МЭРГЭЖИЛТЭН —П.ЭНХСЭЛЭНГЭ

Орхон аймаг 2025 он

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	
Захиалагч байгууллагын нэр хаяг	Орхон аймгийн Байгаль орчны газар, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Захиргааны III байр, 311 тоот.
Ажлын хамрах хүрээ	Орхон аймгийн байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн төлөв байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, тайлант жилүүдийн статистик мэдээ, тайлан, түүний боловсруулалт орно.
Ажлын нэр	"Орхон аймгийн Байгаль орчны төлөв байдлын нөөцийн өөрчлөлтийн 2023-2024 оны тайланг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх"
Ажил гүйцэтгэх үндэслэл	- Байшаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 16 дугаар зүйлийн 16.5, 16.6 дахь заалтууд. - Баян-Өндөр сумын ИТХ-ын 2024 оны 12-р сарын 31-ний өдрийн 17 дугаар тогтоолын 3 дугаар хавсарлтын 2.4.21 дэх заалт
Гүйцэтгэх ажлын иж бүрдэл	"Орхон аймгийн Байгаль орчны төлөв байдлын нөөцийн өөрчлөлтийн 2023-2024 оны тайланг дараах чиглэлээр боловсруулна. Үүнд: 1. ЦАГ АГААР, УУР АМЬСГАЛЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ӨӨРЧЛӨЛТИЙН ХАНДЛАГА ➢ Цаг агаарын тойм, уур амьсгалын өөрчлөлт ➢ Байгалийн аюултай болон гамшигт үзэгдлийн тойм ➢ Тайлант онуудын өвөлжилт, зуншлагын байдал ➢ Мал өвөлжилтийн цаг агаарын тойм ➢ Дүгнэлт 2. БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТ ➢ Газрын нэгдмэл сангийн өөрчлөлтийн төлөв байдал ➢ Газрын хэвлий, уул уурхайн ашиглалтын үеийн байгаль хамгаалал, нөхөн сэргээлт ➢ Усны нөөцийн төлөв байдал, ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлт ➢ Ойн нөөцийн төлөв байдал, ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлт ➢ Биологийн төрөл зүйлийн тархац, сэргээн нутагшуулалт ➢ Байгаль орчны багц хуулийн хэрэгжилт, хяналт шалгалт. ➢ Дүгнэлт 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОХИРДОЛ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨЛӨВ ➢ Агаарын чанарын төлөв байдал ➢ Хөрсний чанарын төлөв байдал ➢ Усны чанарын төлөв байдал ➢ Хог хаягдалын менежментийн өнөөгийн төлөв байдал, ➢ Химийн хорт болон аюултай бодисын хэрэглээ, ашиглалт ➢ Цагаан тоосны тархалт, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ. ➢ Дүгнэлт 4. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ ➢ Аймгийн хэмжээнд аялал жуулчлалыг хөгжүүлэх нөөц, боломж, авч хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээ ➢ Дүгнэлт 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАРЫН БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ ➢ Салбарын эрх зүйн өнөөгийн байдал ➢ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн зарцуулалт ➢ Байгаль орчны үнэлгээний хэрэгжилтийн байдал ➢ Байгаль орчны статистик мэдээ 6. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

	7. ЗӨВЛӨМЖ БАГТСАН БАЙНА. 8. "ОРХОН АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН НӨӨЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН 2023-2024 ОНЫ ТАЙЛАНГИЙН ХЭВЛЭМЭЛ НОМЫГ – **400 ХУВЬ** ХЭВЛҮҮЛЖ, ХҮЛЭЭЛГЭЖ ӨГӨХ
ТАВИГДАХ ШААРДЛАГА	
Чадвар	Гүйцэтгэгч нь зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай дараах чадвар хангасан байна. (чадварыг нотлох бичиг баримтуудыг хавсаргасан). Үүнд: i. Гүйцэтгэгч нь байгаль орчны судалгааны ажлаар мэрэгшсэн магистраас доошгүй цолтой шинжээчдээс бүрдсэн байх ii. Байгаль орчны статистик мэдээ, мэдээллийг цуглуулах, боловсруулалт хийж дүгнэлт, зөвлөмж гаргах чадамжтай байх. iii. Ижил төстэй ажил гүйцэтгэж байсан туршлагатай байх
Техникийн шаардлага	Гүйцэтгэгчийн зөвлөх үйлчилгээ нь дараах шаардлагыг хангасан байна. I. Тайланд ажлын даалгаварт тусгагдсан бүх чиглэлийг тусгасан байна. II. Тайланд тусгагдсан мэдээ, мэдээллүүдийг харьцуулсан график, диаграммаар баяжуулан боловсруулж, бүх салбарийн хэрэглэгчдэд ойлгомжтой, мэдээлэл бүрэн авах боломжтой байх/Тайлант жилүүдийн болон олон жилийн тоон үзүүлэлтүүдийг харьцуулан тусгах/. III. Тайлангийн хэвлэмэл материал нь зөв бичгийн дүрэм, найруулгын алдаагүй, цаасны чанар, өнгө, зураг мэдээллийн хувьд хэвлэлийн стандартыг бүрэн хангасан байна.
АЖЛЫН ХЯНАЛТ, ТАЙЛАН БАРИМТ	
Ажлын хяналт, шалгалт	I. Гэрээт ажлын гүйцэтгэлд захиалагч талаас хүлээн зөвшөөрч баталсан гэрээ, ажлын календарчилсан төлөвлөгөө болон техникийн даалгаврын дагуу хяналтыг тавина. II. Захиалагч нь ажлын гүйцэтгэлтэй холбоотойгоор нэмэлт мэдээ мэдээлэл гаргуулж авах эрхтэй. III. Тайланг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж, санал, зөвлөмжийг тайланд тусгасан байна.
Тайлан, материал хүлээлгэн өгөх	Гүйцэтгэгч нь төслийн хүрээнд дараах тайлан, зөвлөмж болон бусад холбогдох мэдээллийг гэрээний талуудад хүлээлгэн өгнө. Үүнд: i. Гүйцэтгэгч нь явцын болон үр дүнгийн тайланг ажил гүйцэтгэх каленьдарчилсан төлөвлөгөөний дагуу гаргаж, хэвлэмэл болон файл хэлбэрээр талуудад хүлээлгэж өгнө. ii. Гэрээний талуудад хүлээлгэн өгөх хэвлэмэл тайлан, бусад дагалдах материал бүгд эх хувь байна. iii. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу тайлангийн 400 хувь хэвлэмэл номийг захиалагчид хүлээлгэж өгнө.
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА	
Ажил эхлэх	Ажил гүйцэтгэх гэрээнд заасны дагуу
Хугацаа	Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэх календарчилсан төлөвлөгөөг урьдчилсан байдлаар бэлтгэж захиалагчид танилцуулан батлуулсны дараагаар ажлыг эхлүүлнэ. Ажил гүйцэтгэх хугацааг ажил гүйцэтгэх гэрээнд заасны дагуу тооцно.
ХАВСРАЛТ	Тухайн ажилтай холбоотой статистак тайлан, зураг, схем зэрэг бусад мэдээллийг хавсралтаар тусгаж өгнө.